

# Living the Lotus 9

Buddhism in Everyday Life

2024  
VOL. 228



Америк дахь гишүүд Лос-Анжелас хотын япон хотхоны  
“Нисэи долоо хоног” баярын жагсаалд оролцов. (2024.08.11)



Photos: Richard Kano

## Living the Lotus Vol. 228 (2024.09)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Бодь сэтгэлээ хөгжүүлж, бурханлаг мөн чанараа гаргаж ирэх нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Бярман, Шагжамүни бурхан хоёрын яриа

Байгууллагын 60 жилийн ой тохиосон жил (1998) би “Якүшин” (Коосэй хэвлэлийн газар) сэтгүүлд ингэж бичиж байсан:

“Би ч гэсэн бага байхдаа тутаргын талбай боловсруулах ажилд тусалдаг байлаа. Боловсруулсан хөрс, боловсруулаагүй хөрс хоёр өөр. Боловсруулаагүй хөрс нягт, хатуу учраас юу ч хүлээж авдаггүй. Харин сайтар боловсруулсан хөрс зөөлөн сийрэг тул ус чийг, бордоог ихээр өөртөө шингээдэг. Үүний нэгэн адил сайтар боловсорч хөгжсөн сэтгэл уян хатан, автагдах сэтгэл үгүй, ямар ч зүйлийг байгаагаар нь хүлээж авч чаддаг.” Би ийнхүү хүн бүр “бодь сэтгэлээ хөгжүүлэх” нь ямар чухал ач холбогдолтой болохыг дамжуулсан. Миний ингэж өгүүлсэн нь Шагжамүни бурхны “Суттанипата” сударт өгүүлсэн үлгэр домог, шүлгийн түүврээс улбаатай. Энэ сарын айлдварт тэр талаар дахин танилцуулъя.

Нэгэн газрын эзэн бярман тариан талбайгаа боловсруулах бэлтгэлээ хангачихаад газар тариалангийн ажилд тусалсан хүмүүст идэх юм тарааж яваад бадар барьж явсан Шагжамүни бурхантай таараад ширүүн төрхтэй ийн асуужээ: “Та ч гэсэн хөрс шороо боловсруулж, үр цацаж идэх юм олж идвэл дээргүй юу?” Гэтэл Шагжамүни бурхан уужуу тайвнаар “Би ч гэсэн газар шороо боловсруулж, үр цацах болно.” гэж хэлжээ. Бярман үл итгэсэн шинжтэй байсан тул шүлэглэн ийн өгүүлсэн байна:

-Сүсэг бишрэл бол миний цацах үр, дадлага бол бороо. Бэлгэ билиг бол анжис, ичих сэтгэл бол шалан мод (тэрэгний арлыг буулгатай холбох мод). Сэтгэл бол олс, эргэцүүлэл бол анжисны ир.

-Бие, үг хэлээ цэгнэж, идэж уухаа багасгаж, хэтрүүлж идэхгүй байх.

-Үнэнийг хамгаалах нь миний хувьд өвс хадах юм.

-Үхрийн буулгыг тайлах нь дөлгөөн зангийн илэрхийлэл.

-Хичээл зүтгэл бол ачаа зөөх үхэр бөгөөд амар амгаланд хүргэнэ.



- Ухарч няцашгүй тэмүүлэлд харуусал үгүй.
- Энэ мэт боловсруулах аваас үхэшгүй мөнхийн үр шимийг хүртэнэ.
- Бодь сэтгэлээ хөгжүүлснээр хамаг зовлонгоос ангижирна.  
(«Бодь сэтгэлээ хөгжүүлэх», Нивано Ничикоо, Коосэй хэвлэлийн газар)

Эдгээр шүлгээс Шагжамүни бурхны амьд ахуй цаг үеийн Энэтхэгийн газар тариалангийн дүр зураг харагдана. Японд ч гэсэн эрт дээр үед үхрээр анжисыг чирүүлэн тариан талбайг боловсруулах нь газар тариалангийн гол ажил байсан. Шагжамүни бурхан тариан талбай (сэтгэл)-н газар шороог сэндийлэн ухах анжисыг бэлгэ билиг гэсэн ба үхэр анжис (бэлгэ билиг)-ыг сайтар хөдөлгөхийн тулд үхэр, анжис хоёрыг холбох шалан модны ач холбогдол нэн чухал ажээ. Шүлгээс үзвэл “ичих сэтгэл нь шалан мод” учраас ичих сэтгэл байж байж өөрийгөө эргэцүүлдэг буюу анжис ирлэгдэж, өөртөө дүгнэлт хийхээ умартсан үедээ анжисны ирийг саваагаар цохиж шороог унаган бэлгэ билиг (анжис)-ийг бүрэн ажиллуулах юм бол сэтгэл (тариан талбай) сайтар боловсрон хөгждөг байна.

### Энэ бол бурхны сургаал

Шагжамүни бурхан тариан талбай боловсруулах гэж буй хүмүүст хандан уран арга ашиглан хөрс шороо боловсруулах лугаа хүмүүсийн сэтгэлд сүсэг бишрэлийн үрийг суулган үрслүүлж, түүний үр шимийг хүртэх чухал хэмээн ойлгомжтой айлдсан. Бурхны шашин судлаач эрдэмтэн Масүтани Фүмио гуай (1902–1987) эдгээр шүлгийг тухайн нөхцөл байдалтай уялдсан гайхалтай сургаал хэмээн магтан бишрээд зогсохгүй “бурхны шашны ерөнхий агуулга хийгээд мөн чанарыг бүрэн төгс, бодитой илэрхийлсэн” гэж дурдсан байдаг. Сүсэг бишрэлийн үр сэтгэлийн хөрсөнд сууваас зовох юмгүй сэтгэлийн амар амгаланд хүрэх ба хамаг зовлонгоос ангижирах ажээ. Мөн амар амгаланг хүсэмжлэх олон түмний хүсэл залбиралыг энэ богинохон шүлгэнд шингээсэн тул тус сургаалыг сонссон олон хүн амьдрах хүсэл мөрөөдөл, өөдөө алхах эрч хүчийг олж авсан нь дамжиггүй.

Гэхдээ ганц удаа бодь сэтгэлээ хөгжүүлээд зовлон алга болох уу гэвэл би бол үгүй гэж бодож байна. Дахин давтан хөгжүүлж, тэр болгондоо бурханлаг чанараа ил гаргах чухал ба тэр нь амар амгаланд хөтлөх дөт зам болов уу. Дараа сарын дугаарт бурханлаг мөн чанараа хэрхэн олж анзаарах талаар бага зэрэг гүнзгийрүүлэн авч үзэх болно.

“Косей” сэтгүүл, 8-р сарын дугаараас



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)


## Нийгэмлэгийн тэмдэглэлт баяр ёслолууд

### Бурхны шашны гурван том баяр ёслол

Бурхны шашинд дараах гурван үйл явдлыг гурван том баяр ёслол гэж үздэг бөгөөд Рисшо Косей Кай байгууллага ч мөн адил тус өдрүүдэд Их Ариун ордон, салбар нийгэмлэгүүд дээр ёслолын үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Эдгээр нь туйлын үнэний сургаалыг номлосон Шагжамүни бурхан багшид талархах өдрүүд болно. Мөн бурхны сургаалыг хэрэгжүүлж, олон түмний сайн сайхны төлөө хүчээ зориулахаа амладаг өдөр билээ.

Бурхан багшийн гэгээрлийг олсон өдөр  
(4 сарын 8)



Бурхан багшийн нирваанд орсон өдөр  
(2 сарын 15)



Бурхан багшийн мэндэлсэн өдөр  
(12 сарын 8)

#### Бяцхан мэдлэг

Бурхан багшийн мэндэлсэн өдрийн ёслолын үеэр цэцгээр чимэглэсэн “Ханамидо” дахь Шагжамүни бурхны хөшөөн дээр амтат цай асгадаг. Энэ нь Бурхан багшийг төрөх агшинд тэнгэрээс луу бууж ирэн анхилуун үнэрт усанд булхсан хэмээх домгоос үүдэлтэй.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Шинэ оны эхний өдрийн мөргөл



1-р сарын 1-ий өдөр бол шинэ онтой золгож буйдаа талархаж, ирж буй ондоо аз жаргал, амар амгаланг хүсэн ерөөдөг өдөр юм.

Рисшо Косей Кай нийгэмлэгийнхэн ч гэсэн өглөө эрт ёслол үйлдэж, Их Ариун ордон, нийгэмлэгтээ очиж шинэ жилээ тэмдэглэдэг.

Гол шүтээний өмнө шинэ оноо тэмдэглэхээс гадна өөртөө зорилго тавьж түүнийгээ хэрэгжүүлэхээ тангарагладаг.

Энэхүү зорилгыг “кэцүжоо” буюу тангараг гэж хэлдэг. Зорилгодоо хүрэхийн төлөө хичээнгүйлэн ажиллахаа амлаж, дэлхийн энх тайвны төлөө залбирах ахуйд сэтгэл сэргэж, сайхан болдог.

### Бяцхан мэдлэг

“Кэцүжоо” нь итгэл дүүрэн, эргэлзэхгүйгэсэнбайхутгатай. Энэ нь зүрх сэтгэлдээ хатуу шийдвэр гаргах гэсэн үг бөгөөд Рисшо Косей Кай байгууллагад их хэрэглэгддэг үг юм. Шинэ оны эхний өдөр гаргасан “кэцүжоо” буюу тангарагаа бүтэн жилийн турш санаж мөрдөх чухал.

Шагжамүни бурхны эрин үе рүү аялсан нь

Акагава Кэйичи

Японд рекорд тогтоосон халуун, аадар бороотой зун арайхийн дуусах дөхсөөр аанай халуун өдрүүд үргэлжилж байгаа ч хуанлигаар бол намар цаг ирж байна.

Та бүхний нутаг оронд ямар байна вэ?

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвараараа Сүттанипата сударт өгүүлдэг Шагжамүни бурхны талаарх домог, шүлэг найргийг танилцуулж, “Хэзээд бодь сэтгэлээ хөгжүүлж тэр болгондоо өөрийн бурханлаг мөн чанарыг нээн илрүүлэх чухал бөгөөд энэ нь сэтгэлийн амар амгаланд хүргэдэг” гэж сургасан.

Газрын эзэн бярмануудад сэтгэлээ боловсруулахын чухлыг сургаж буй энэхүү шүлгийн цаад утга нь Шагжамүни бурхны амьд ахуй үеийн Энэтхэгийн газар тариалангийн амьдралтай холбоотой.

Би 2010 оны 4-р сарын 9-өөс 22-ны хооронд тус нийгэмлэгийн “Буддын шашны дурсгалт газруудад мөргөх 34-р мөргөл”-ийн гишүүн болж Энэтхэгийн зүүн хойд хэсэгт орших Бихар мужийг тойрон Бурхан багштай гүнзгий холбоотой газруудаар тойрон аялсан билээ. Буддын шашны түүхэн дурсгалт газруудыг хэвээр хадгалахын тулд орчин үеийн бүтээн байгуулалтаас зайлсхийсэн газар нутаг болохоор ч тэр үү аялалын автобусны цонхоор хөдөө нутгийг харахад 2600 жилийн өмнө Шагжамүни бурхны хөл нүцгэн аялж байсан Энэтхэг рүү буцаж очсон мэт санагдуулам сэтгэл хөдөлгөсөн аялал байлаа. Өргөн уудам тариан талбайд хараа бэлчээх үед Сүттанипата сударт гарч буй Шагжамүни бурхны уран яруу сургаалын үгсийн утгыг бодитоор сонсож ойлгох мэт болж, сэтгэл догдолж байсан. Энэтхэгээр аялсан аяллаа эргэн санаж, энэ сарын айлдварыг уншаад сэтгэлээ боловсруулахын утга учрыг дахин ойлголоо. Энэ сард би өдөр бүрийг “бодь сэтгэлээ хөгжүүлэх”, “өөрийн бурханлаг мөн чанарыг нээн илрүүлэх”-ийн төлөө хичээх болно.




2024 оны 7 сарын 14, Солонгос салбарт болсон “Номын багшийн сургалт”-ын дараах дурсгалын зураг (урд эгнээний голд Акагава хэлтсийн дарга)

# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## A Global Buddhist Movement



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)